

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН  
ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА

2026 оны 5 сарын 11

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Эрүүл аюулгүй орчны хэм хэмжээг тодорхойлох, стандартчилах, шинэчлэх ажлыг нийгэм, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилгоор энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Монгол Улс хүлээн зөвшөөрч нэгдэн орсон Олон улсын болон Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээр, конвенцуудад тусгагдсан Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэг Улс-Нэгдсэн стандарт” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг боловсронгуй болгох” гэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжид Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн орчинг олон улсын жишигт нийцүүлэх талаар тус тус заасан.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжид стандартыг сонгон хэрэглэх баримт бичиг гэж заасан нь иргэд, аж ахуйн нэгж болон төрийн хяналт шалтгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан болон иргэн, аж ахуйн нэгжийн хооронд үл ойлголцол бий болж тодорхойгүй байдал, ойлголтын зөрүү үүсгэж байна.

Монгол Улсад одоогийн байдлаар 6689 стандарт хүчин төгөлдөр байгаа ч тэдгээр стандартыг дагаж мөрдөхгүй байгаагаас шалтгаалан хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөөллийг бий болгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Иймд цаашид стандартыг дагаж мөрдөх, хэвшүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Монгол Улсын хөгжлийн баримт бичигт дурдсан стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн болоод хүн амын аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн 50-аас дээш хувьд өөрчлөлт орсон тул хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, үзэл баримтлалыг Монгол Улсын Шадар сайд Н.Номтойбаяр болон Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан нар 2026 оны 5 сарын 5-ны өдөр хамтран баталсан.

Тус хуулийн төслийг 2022-2026 онд нийслэл, 21 аймгийн иргэд, аж ахуй нэгж, төр захиргааны байгууллага, мэргэжлийн холбоодын дунд 60 гаруй хэлэлцүүлэг, 2026 оны 5 дугаар сард Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ Дархан аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн ажиллагсадын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 16,350 оролцогчийг хамруулж, саналыг тусгасан болно.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль 8 бүлэг, 32 зүйлтэй, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 9 бүлэг, 53 зүйлтэй ба дараах асуудлыг тусгасан. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчиллын баримт бичгийг “сонгон” хэрэглэнэ гэсэн нь олон нийтэд стандартыг “сонголт”-оор мөрдөж болох ташаа ойлголт бий болгож байгаа тул стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөх;
- Хуулийн зорилт, зарчим, нэр томъёог шинэчилж, стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллага, түүний тогтолцоо, салбар дундын зохицуулалтыг нарийвчлан тусгасан;
- Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актаар зохицуулж буй зарим харилцааг хуулийн төсөлд тусгасан;
- Чиг үүргүүдийн давхардлыг арилгах;
- Монгол Улсын хэмжээнд дагаж мөрдөх стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэлэлцүүлэх, батлах үйл явцыг тодорхой болгож олон талын оролцоог нэмэгдүүлэх;
- Тохирлын үнэлгээний байгууллагуудыг бодлогоор дэмжих, эрх үүргийг тодорхой болгох, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Худалдаан дахь тарифын бус саад тотгорыг арилгах хүрээнд стандарт, тохирлын үнэлгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;
- Стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжилтийн хяналтыг холбогдох эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлэх, зах зээл дээрх болон Улсын хилээр орж ирж буй бараа бүтээгдэхүүн тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавих чиг үүргийг нарийвчлан тусгасан;
- Стандартын баримт бичгийг шинэчлэх, сайжруулах ажлыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагыг үүрэгжүүлэн хуульд тусгасан;
- Мэдээлэл солилцох, тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлсэн бараа, бүтээгдэхүүний статистик мэдээллийг төрийн байгууллага хооронд мэдээллийн сан бий болгох зохицуулалт;
- Чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн эрх үүргийг тодорхой зааж, стандартын хэрэгжилтэд зөвхөн төрөөс хяналт тавих бус иргэн, үйлдвэрлэгч, нийлүүлэгч бүх талын оролцоог хангах;
- Сорьцын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төрийн хяналтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтыг шинээр болон шинэчлэн тус тус тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар стандартыг батлах, хэрэглэх, хэрэгжүүлэх тогтолцоо боловсронгуй болж, олон улсын нийтлэг жишигт нийцсэнээр дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг олон улсад зөвшөөрөх, гадаад худалдаа, экспортыг хөнгөвчлөх нөхцөл сайжирна. Түүнчлэн стандартын хэрэгжилт хангагдаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдана.

---oOo---